

МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЧИН ЧАДАЛ, ХЭРЭГЦЭЭГ ҮНЭЛЭХ

Санхүүгийн зөвлөх сонгон шалгаруулалтын удирдамж

1. ЕРӨНХИЙ ЗОРИЛГО БА ЧИГЛЭЛ

1.1 Үндсэн зорилго

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/132 дугаар тушаалын хавсралтад заасан зарим арга хэмжээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт, нөөцийн зохистой байдал, нэмэлт шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг үнэлэх үүрэг бүхий зөвлөхийг сонгон шалгаруулах.

1.2 Үйл ажиллагааны хамрах хүрээ

- Үнэлгээ хийх аргачлалыг нийгмийн эрүүл мэндийн зөвлөх болон үнэлгээг хариуцсан зохицуулагчтай хамтран боловсруулж Эрүүл мэндийн хөгжлийн төв болон Эрүүл мэндийн ямаар хэлэлцүүлж, батлуулах;
- Батлагдсан аргачлал болон хуваарийн дагуу үнэлгээ хийх судлаачдыг чадавхжуулах, дэмжлэг үзүүлэх, удирдлага, арга зүйгээр хангах;
- Үнэлгээний аргачлалын дагуу судлаачдын цуглуулсан мэдээллийг боловсруулах, үр дүнг нэгтгэх;
- Үнэлгээний үр дүнг хэлэлцүүлэх, үр дүнг танилцуулах хурлыг нийгмийн эрүүл мэндийн зөвлөх болон үнэлгээг хариуцсан зохицуулагч, холбогдох ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулах;

1.3 Санхүүжүүлэгч

- *Үндсэн санхүүжүүлэгч:* ЭМЯ, Глобаль сангийн ДОХ/Сүрьеэгийн төсөл;
- *Хяналт хэрэгжүүлэн санхүүжилт олгогч:* Эрүүл мэндийн хөгжлийн төв;

2. ЗӨВЛӨХИЙН ШААРДЛАГА

2.1 Мэргэжлийн шаардлага

Заавал байх ёстой чадвар:

- Эрүүл мэндийн эдийн засаг эсхүл санхүү, эдийн засаг болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр давхар мэргэшсэн;
- Нийгмийн эрүүл мэндийн чиглэл эсхүл эрүүл мэндийн санхүүгийн удирдлагын чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлага;
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, барилга байшин, хөрөнгө оруулалт, технологи, тоног төхөөрөмжийн тогтолцооны чиглэлээр ахисан түвшний мэдлэгтэй байх;

Давуу талууд:

- Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалтад ажиллаж байсан туршлага;
- Эрүүл мэндийн системийн үнэлгээ, тооцоолол, аудитын туршлага;
- Эрүүл мэндийн үзүүлэлт, мониторинг үнэлгээний аргазүйд ажилласан туршлага;
- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт ажилласан туршлага;
- Судалгаа, шинжилгээний ажил хийсэн туршлага;
- Бодлого боловсруулалт, стратегийн төлөвлөлтөд оролцсон туршлага;

2.2 Техникийн шаардлага

- Эрүүл мэндийн мэдээллийн систем, мэдээллийн технологийн үндсэн мэдлэг;
- Өгөгдлийн шинжилгээ, тайлангийн бэлтгэлийн чадвар;
- Баримт бичгийн боловсруулалт, хянан үзэх чадвар;
- Илтгэх, чиглүүлэх ур чадвар;

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

3.1 Хяналт, үнэлгээ:

- Хэрэгжилтийн явцыг хангах;
- Сайжруулах санал, зөвлөмж боловсруулах, бусад ижил төрлийн судалгаа, үнэлгээтэй хослуулах;
- Үнэлгээний тайланг бэлтгэх, танилцуулах, хэлэлцүүлэх, санал авах, ЭМЯ, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төсөлд хүргүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.2 Хүлээгдэж буй үр дүн

- Үнэлгээ хийх аргачлалыг бусад зөвлөхүүдтэй хамтран боловсруулж батлуулна;
- Аргачлалын дагуу судлаачдыг арга зүйгээр хангаж, мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлнэ;
- Судлаачдын цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нийгмийн эрүүл мэндийн төв байгуулахад шаардлагатай нөөцийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлно;
- Зохицуулагч болон бусад зөвлөхүүдтэй хамтран үнэлгээний үр дүнг нэгтгэж, тайлан боловсруулна;
- Тайланг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Глобаль сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн холбогдох төлөөллүүдэд танилцуулж, сайжруулалт хийж, хүлээлгэж өгнө;

4. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

4.1 Ажлын хугацаа

- Ажлын 60 хоногийн хугацаатай гэрээ
- Эхлэх огноо: Гэрээ байгуулснаас хойш

4.2 Цалин, урамшуулал

- Нийт ажлын хөлс 13,500,000 (арван гурван сая таван зуун мянган) төгрөг;
- Нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ыг өөрөө хариуцан төлнө;

5. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

5.1 Өргөдөл гаргахад шаардлагатай баримт бичиг:

1. Анкет (CV) болон зөвлөхөөр сонгогдохыг хүссэн захидал;
2. Боловсролын гэрчилгээний хуулбар;
3. Ажлын туршлага, ур чадварыг баталгаажуулах бусад баримт;

5.2 Сонгон шалгаруулалт хийх байгууллага

1. Сонгон шалгаруулалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төв зохион байгуулна.

6. ХУВААРЬ БА ХЯНАЛТ

6.1 Сонгон шалгаруулалтын хуваарь

- Зарлах: 2025.06.16
- Өргөдөл хүлээн авах сүүлийн өдөр: 2025.06.20-ны 17:00 цаг хүртэл
- Баримт шалгах: 3 ажлын өдөр
- Өргөдлийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 103 тоот өрөөнд хүлээн авна

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ